



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 448

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн харьяа Баян-Өлгий аймаг, Өвөрхангай аймаг дахь Шүүхийн шинжилгээний албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 41,541,400.00 (дөчин нэгэн сая таван зуун дөчин нэгэн мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахын зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг (худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000858

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 29 ны өдрийн
448 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ХАРЬАА БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ,
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЬ ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ

Д/д	Автомашинь нэр, улсын бүртгэл, арлын дугаар	Ашигла лтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ үнэ (төгрөг)
1. Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шинжилгээний алба							
1	Nissan X-Trail, 53-99 БӨТ (арал nt30000968)	2000	128600	15,900,000.00	15,900,000.00	-	500,000.00
	Дүн			15,900,000.00	15,900,000.00	-	500,000.00
2. Өвөрхангай аймаг дахь Шүүхийн шинжилгээний алба							
2	Nissan X-Terra, 79-00 ӨВР (арал 5n1ed28y12c534248)	2009	190000	25,641,400.00	25,641,400.00	-	500,000.00
	Дүн			25,641,400.00	25,641,400.00	-	500,000.00
	Нийт дүн			41,541,400.00 (дөчин нэгэн сая таван зуун дөчин нэгэн мянга дөрвөн зуун)	41,541,400.00 (дөчин нэгэн сая таван зуун дөчин нэгэн мянга дөрвөн зуун)		1,000,000.00 (нэг сая)